2132	Бусад урсгал шилжүүлэг	158,437,000.00	156,259,995.00	156,259,995.00	0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,366,500.00	21,189,495.00	21,189,495.00	0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	130,323,900.00	130,323,900.00	130,323,900.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,746,600.00	4,746,600.00	4,746,600.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	271,287,500.00	234,020,161.00	234,020,161.00	0
221001	Их засвар	44,421,000.00	42,674,610.00	42,674,610.00	0
222001	Тоног төхөөрөмж	15,000,000.00	15,000,000.00	15,000,000.00	0
223001	Бусад хөрөнгө	211,866,500.00	176,345,551.00	176,345,551.00	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	170,631,000.00	81,593,630.00	1	81,593,630.00
230001	Эргэж төлөгдөх зээл	170,631,000.00	81,593,630.00	81,593,630.00	0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,246,574,300.00	6,186,270,813.00	6,046,282,696.00	140,508,017.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,383,449,800.00	4,382,873,700.00	5,621,261,500.00	-1,238,387,800.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0	1,238,387,800.00	-1,238,387,800.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	4,383,449,800.00	4,382,873,700.00	4,382,873,700.00	0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,391,069,300.00	1,520,890,600.00	152,681,500.00	1,368,209,100.00
320001	Орон нутгийн төсвөөс	1,238,387,800.00	1,368,209,100.00	1	1,368,209,100.00
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	152,681,500.00	152,681,500.00	152,681,500.00	0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	96,183,100.00	82,810,770.00	82,810,770.00	0
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	96,183,100.00	82,810,770.00	82,810,770.00	0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	375,872,100.00	199,695,743.00	189,528,926.00	10,686,717.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,041,000.00	180,551,018.00	180,551,018.00	519,900.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,800,000.00	19,144,725.00	19,144,725.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	268,031,100.00	0	263,583,327.08	-263,583,327.08
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	133,783,715.08	1	133,783,715.08
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	212,631,955.08	1	212,631,955.08
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,103.00	318,789.00	1	318,789.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	11	11	1	11
610001	Төсвийн байгууллага	11	11	1	11
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0	1	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	317	318	1	318
620001	Удирдах ажилтан	21	21	1	21
620002	Гүйцэтгэх ажилтан	205	206	1	206
620003	Үйлчлэх ажилтан	91	91	1	91
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	2,458.00	318,142.00	1	318,142.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,797.00	1,797.00	1	1,797.00
630001	Төрийн өмчит ЕБС	1,797.00	1,797.00	1	1,797.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	661	316,345.00	1	316,345.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	661	316,345.00	1	316,345.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	317	318	1	318
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	12	12	1	12
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	6	6	1	6
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	3	5	1	5
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	37	37	1	37
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	246	245	1	245
650010	Гэрээт ажилтан	2	2	1	2
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	11	11	1	11

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	428,455,411.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	428,455,411.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	366,909,483.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,968,850.00
210102	Нэмэгдэл	33,968,850.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,399,264.00
210201	Тэтгэврийн даатгал	5,399,264.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	982,000.00
210303	Цэвэр, бохир ус	982,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,071,684.00
210401	Бичиг хэрэг	1,646,150.00
210402	Тээвэр, шатахуун	6,814,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	365,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,245,934.00
2105	Нормативт зардал	248,139,262.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	226,094,262.00
210502	Хоол, хүнс	21,045,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,062,000.00
210702	Дотоод албан томилолт	1,062,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,878,881.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,878,881.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,407,542.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,407,542.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,545,928.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	58,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,545,928.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	3,545,928.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	428,455,411.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	428,455,411.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	32,297,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	45,377,539.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	350,780,472.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Уянга сумын Төрийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.03.22-ноос 2022.03.24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.03.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.03.23-ны өдрийн 01/52 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Сумын төрийн сангийн нэгтгэсэн тайланд 11 төсөвт байгууллага, 3 сан, 1 ерөнхий орлогын данс нийт 15 тайлан нэгтгэгджээ.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно." гэж заасан.

Мөн хуулийн 36.1."Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно." гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Уянга сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Уянга сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож,

Уянга сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 8 тэрбум 903.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 89.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 66.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 166.4 сая төгрөгөөр өссөн байна.

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	259.3	425.7	166.4
31211	Төрийн сангийн харилцах	259.3	425.7	166.4
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.02	0	-0.02

Дараах байгууллагуудын данс мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сая төгрөг

Орон нутгийн ерөнхий орлого	213.1
Эрсдэлээс хамгаалах сан	39
Сум хөгжүүлэх сан	138.1
ОНХСан	35.5

Created with Datawrapper

3.5.2 Авлага

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Эзлэх хувь
33	АВЛАГА	438.4	531.7	93.3	100
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	16.5	69.8	53.3	13.13
33300	Татаас, санхүүжилтийн авлага	13.6	153.7	140.1	28.91
33400	Зээлийн хүүгийн авлага	20	10.3	-9.7	1.94
33401	Дансны авлага /ТӨҮГ/		0.4	0.4	0.08
3351	Байгууллагаас авах авлага	14.9	1.1	-13.8	0.21
3352	Хувь хүмүүсээс авах авлага	373.3	296.4	-76.9	55.75
34	УРЬДЧИЛГАА	42.9	0	-42.9	0.00

Тайлант оны нийт авлагын 55.7 хувийг хүмүүсээс авах авлага эзэлж байна.

Хувь хүмүүсээс авах авлагын 296.1 сая төгрөг нь СХСангаас олгосон зээлийн авлага, 0.2 сая төгрөг нь Жаргалантын цэцэрлэгийн авлага байна.

Төсвийн бүх байгууллагууд ажиллагсадаас авах авлагатай гарсан байна. ЭМТөв ЭМДСангаас 153.7 сая төгрөгийн авлагатай гарчээ.

3.5.3 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 292.4 сая төгрөгөөр өссөн байна.

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Эзлэх хувь
35	БАРАА МАТЕРИАЛ	290.9	583.3	292.4	100
351	Түүхий эд материал	29.6	171.1	141.5	29.3
354	Хангамжийн материал	213.6	364.6	151	62.5
35600	Мал амьтад	47.6	47.6	0	8.2
36	НӨӨЦИЙН БАРАА	102.4	53.1	-49.3	

Тайлант онд бараа материалын үлдэгдэл ЭМТөвд 117.0 сая төгрөгөөр, Жаргалантын эмнэлэгт 19.5 сая төгрөгөөр, ЗДТГазарт 25.1 сая төгрөгөөр, сая төгрөгөөр сургуулиудад 51.7 сая төгрөгөөр өссөн нь ковидын эмчилгээ үйлчилгээтэй холбоотой эм боох материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэн байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 671.1 сая төгрөгөөр өссөн байна.

Код	Үзүүлэлт	Хөрөнгийн дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	16,769.60
2	Нэмэгдсэн	1,143.70
201	Худалдан авсан	149.00
202	Хандиваар	0.20
203	Шилжүүлэн авсан	42.70
205	Бусад	781.80
206	Дахин үнэлгээний нэмэгдэл	170.00
3	Хасагдсан	472.60
302	Акталсан	120.50
303	Шилжүүлсэн	49.40
305	Бусад	24.50
306	Дахин үнэлгээний хорогдол	278.20
4	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	17,440.70

Уянга сумын Төрийн сангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн нэгтгэлээр 1 тэрбум 143.7 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 149.0 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 994.7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусгажээ. Харин 120.5 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, 49.4 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн, 278.2 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэхээр данснаас хассан байна.

Тайлант онд сумын хэмжээнд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 382.6 сая төгрөгийн барилга байгууламжийг шинээр бүртгэсэн, 130.0 сая төгрөгөөр тээврийн хэрэгсэл, 366.4 сая төгрөгөөр машин тоног төхөөрөмж, 95.5 сая төгрөгөөр тавилга эд хогшил, 72.2 сая төгрөгийн зам гүүрийн байгууламж, 7.4 сая төгрөгөөр ном, 1.0 сая төгрөгөөр программ хангамж, 88.5 сая төгрөгөөр бусад биет бус хөрөнгийг тус тус бэлтгэсэн байна.

3.5.5 Өр төлбөр

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Эзлэх хувь
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	43.8	232.6	188.8	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	43.8	232.6	188.8	100
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.7	128.6	127.9	55.3
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	11.1	87.5	76.4	37.6
41361	Байгууллагад төлөх өглөг	31.9	14.7	-17.2	6.3
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		1.8	1.8	0.8

Тайлант онд өр төлбөр 188.8 сая төгрөгөөр өссөн нь ЭМТөв, Жаргалантын эмнэлэг ЭМДСангаас санхүүжилтээ дутуу авсан учраас ажилчдад өгөх 115.2 сая төгрөгийн, бараа үйлчилгээний төлбөрт 87.4 сая төгрөгийн, байгууллагад төлөх 13.0 сая төгрөгийн өглөгтэй гарсан нь гол нөлөөг үзүүлжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

3.6.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2020 оны 2/04 тоот тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 249.4 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр 432.9 сая төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөө 183.5 сая төгрөг буюу 73.6 хувиар давж биелжээ. Энэ нь төлөвлөгдөөгүй малд ногдуулах албан татвар 112.5 сая төгрөгийн орлого орсонтой холбоотой байна.

Төлөвлөсөн татвараас бууны татвар 52.8 хувиар, улсын тэмдэгтийн хураамж 25.3 хувиар, газрын төлбөр 81.6 хувиар тасарсан байна.

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	20,000	25,820	5,820	129.1
2	Хөрөнгийн орлого	91,320	115,854	24,534	126.9
3	Хөрөнгө борлуулсны орлого	400	15,989	15,589	3997.3
4	Бууны албан татвар	8,490	4,009	(4,481)	47.2
5	Улсын тэмдэгтийн хураамж	6,000	4,483	(1,517)	74.7
6	Түгээмэл тархацтай АМНАТ	500		(500)	0.0
7	Хог хаягдлын хураамж	35,000	105,527	70,527	301.5
8	Газрын төлбөр	59,200	10,913	(48,287)	18.4
9	Малд ногдуулах татвар		112,473	112,473	
10	Ан амьтны нөөц ашигласны төлбөр			-	
11	Нохойны татвар			-	
12	Ойн төлбөр	8,500	10,320	1,820	121.4
	Татварын орлого	229,410	405,388	175,978	176.7
1	Татварын бус/ Хүү, торгуулийн орлого	20,000	27,561	7,561	137.8
	Нийт дүн орлого	249,410	432,948	183,538	173.6

3.6.2 Орон нутгийн төлөвлөлт, гүйцэтгэл

2021 онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 6 тэрбум 246.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 4 тэрбум 383.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 1 тэрбум 391.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 96.2 сая төгрөгийг ЭМДСангаас, 375.9 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4 тэрбум 382.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 1 тэрбум 520.9 сая төгрөг, ЭМДСангаас 82.8 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 199.7 сая төгрөг, нийт 6 тэрбум 186.3 сая төгрөгийн санхүүжилт, болон орлогын эх үүсвэр бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 5 тэрбум 590.3 сая төгрөг, хөрөнгийн зардалд 234.0 сая төгрөг, эргэн төлөгдөх зээлд 81.7 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 156.2 сая төгрөгийг зарцуулж, нийт 6 тэрбум 62.2 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар сумын хэмжээнд 428.4 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд 386.9 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 61.5 сая төгрөг зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Уянга сумын Төрийн сан нь 2021 онд Шилэн дансны сайтад 155 мэдээлэл оруулахаас 152 мэдээллийг оруулж, Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг мэдээлээгүй байна. 13 мэдээллийг хугацаа хоцроосон байна. 2 мэдээллийн хугацаа болоогүй байна. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар алдаа зөрчил илрээгүй.

3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 5.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар тооцож бүртгэсэн үр өгөөж байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Уянга сумын Төрийн сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэгэжүүлээгүй зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулга гараагүй.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

3.3 Албан шаардлага

Албан шаардлага гараагүй.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх талаар

Илрүүлэлт:

Шилэн дансны сайтад 155 мэдээлэл оруулахаас 152 мэдээллийг оруулж, Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг мэдээлээгүй байна. 13 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Өгсөн зөвлөмж:

Зөвлөмж-1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад **2022 оны 05 дугаар сарын 25-ны** өдрийн дотор ирүүлнэ үү.

4.5 Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 13 байгууллагаас 7 байгууллагад дүгнэлт гаргаж 6 байгууллагыг түүвэрт хамруулсан. / Зөрчилгүй 7 дүгнэлт /

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр **398.4** сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 239.3 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 159.1 сая төгрөгийн зөрчилд 156.1 сая төгрөгийн 14 албан шаардлага, 3.0 сая төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүлсэн.

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчсөн **25.3** сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн.

Соёлын төвд- 116.4 мянган төгрөгийн нормын хувцас, 16,000.0 мянган төгрөгийн автомашин, 1,025.6 мянган төгрөгийн тавилга худалдан авсан байна.

1 дүгээр цэцэрлэгт- 502.2 мянган төгрөгийн ажлын хувцас, 1554.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил бэлтгэсэн.

ЗДТГазарт-5.8 сая төгрөгөөр хувцас худалдан авсан, уралдаан тэмцээн зохион байгуулсан байна

- Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **262.3** сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Үүнд:

Жаргалантын сургуульд- Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл санхүүгийн тайлангийн хөрөнгийн тодруулага тайлантай зөрүүтэй тайлагнасан 11105.7 мянган төгрөг

СХСанд- Хариуцагч эзэнгүй зээлийн үлдэгдэл 8842.2 мянган төгрөгийг сангийн тайланд зээлийн авлагаар тусгасан, Сангийн харилцахын хуулагны үлдэгдлийг 3059.7 мянган төгрөгөөр санхүүгийн байдлын тайлангийн үлдэгдэлтэй зөрүүтэй тайлагнасан

1 дүгээр цэцэрлэг- Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 7789.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

2 дугаар сургууль- Үр дүнгийн тайлангийн цалингийн зардлыг мөнгөн гүйлгээний тайлангаар илэрхийлэгдсэн цалингийн гүйлгээтэй тулгахад 21623.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байгаа нь МГ-ний тайланд тайлагнахдаа цалингийн зардлаас НДШ-ийн зардал хооронд гүйлгэж зарцуулснаас зардлууд буруу илэрхийлэгдсэн, 5141.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын дутуу төлөлтийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй ОНӨмчийн хэлтсийн Хөрөнгө оруулалтын жагсаалттай тулгахад Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн сантехникийн 195,375.1 мянган төгрөгийг барилга байгууламжинд капиталжуулалт хийгээгүй зэрэг алдаа зөрчил илэрсэн.

Жаргалантын цэцэрлэг- Төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 9360.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалд бүртгэж, тайлагнасан.

- Дотоод хяналт хариуцлагатай холбоотой **0.3** сая төгрөгийн зөрчил илэрсэн.

ЭМТөв- Эм, эмнэлгийн хэрэгслийн орлого, зарлагыг бараа материалын тайлан, тооллогын бүртгэлд нэр төрлөөр тусгасан боловч санхүүгийн бүртгэлд бөөн дүнгээр бүртгэсэн тул тэдгээр хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт хэрэгжүүлээгүй

Жаргалантын цэцэрлэг-Авлагын бүртгэлд байгаа 250.3 мянган төгрөгийг сүүлийн гурван жил дараалан барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

- Нийцлийн аудитаар **96.0** сая төгрөгийн дараах илэрсэн зөрчил

ОНХСан- Аудитын баримтын тулгалтаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахтай холбоотой 7 төрлийн 77576.1 мянган төгрөгийн шийдвэрийг шилэн дансны сайтад мэдээлээгүй байна.

1 дүгээр цэцэрлэг- Шилэн дансны сайтад 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

ЗДТГазар- 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансанд мэдээлэл дутуу байршуулсан , 19 мэдээлэл хугацаа хоцорсон

1 дүгээр сургууль- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-ийн "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-д 596.2 сая төгрөгийн мэдээлэл дутуу байршуулсан

2 дугаар сургууль- Мөнгөн орлого зарлага болон бусад мэдээллийг Шилэн дансны сайтад байршуулсан мэдээлэлтэй тулгахад 148 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан 11 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Жаргалантын ЭМТ- Шилэн дансанд Нийт 149 мэдээлэл оруулахаас 23 мэдээг хугацаа хоцроосон байна

- Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой **10.6** сая төгрөгийн зөрчил илэрсэн.

2 дугаар сургууль- Үдийн цайны зардлыг 100 хувь шалгахад үдийн цайнны зардалд зарцуулаагүй үлдсэн мөнгөөр 6000.0 мянган төгрөгийн материалыг нөөцөлж үлдээгдлээр тайланд тусгажээ.

Уянга сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1 дүгээр цэцэрлэгт- Хүүхдийн хоолны зардлаас 670.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан, хоолны зардлаас хэмнэгдсэн 3914.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэлгүй хүнс нөөцөлсөн.

- Зориулалт бус зарцуулалттай холбоотой 3.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Соёлын төв- Тус байгууллагын урсгал зардлын санхүүжилтээс 1,400.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн

ИТХурал- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлаас 257.1 мянган төгрөгийг цалингийн зардалд зориулалт бус зарцуулсан

ЭМТөв- Урсгал зардлаас 2234.9 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Уянга сумын Төрийн сан	0	0	0	00	0	0	0	0	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ө.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР